
Доктор (Sc.D), профессор Ц.ГОМБОСҮРЭН
МУИС-ийн Философийн тэнхмийн тэргүүлэх профессор

2.2. ШИНЭ ГЭРЭЭГ АТЕИСТ ШИНЖТЭЙ ХЭМЭЭН Ф.НИЦШЕ ҮНДЭСЛЭСЭН НЬ

Түлхүүр үгс: *Нигүүлсийн шашин, Ressentiment шашин, Бие, Гэрэл, Сүүдэр,
Үд, Бүрэнхий, Уналт, Сайн, Муу*

Оршил хэсэг

Ф.Ницше ертөнцийг үзэх философи үзлийн хувьд теист үү эсвэл атеист уу гэдэг талаар судлаачид өөр өөр тайлбар өгч иржээ. Манайд ч гэсэн энэ чиглэлээр судалгаа явагдаж эхэлсэн нь монголчууд Ф.Ницшегийн философитой гүнзгий танилцахад чухал түлхэц болно гэж үзэж байна¹.

Энэ өгүүллийг бичигч миний бие өөрийн судалгааны үр дүнд Ф.Ницшегийн философи үзэлд холбогдох дараахь хоёр дүгнэлтэнд хүрсэн болно. Үүнд: нэгдүгээрт, Библийн эхний хэсэг болох Дивангарын Гэрээ (англиар "Old Testament", оросоор "Ветхий завет" гэдэг нэрийг манайхан "Хуучин гэрээ" гэж орчуулдаг нь уг бүтээлийг эдүгээ үед хуучирсан, хэрэггүй болсон гэдэг утгатай болгодог байж магадгүй санагддаг тул "хуучин" гэхийн оронд "дивангарын" гэхийг дээр гэж сонгов)-г хэрвээ ертөнцийг үзэх философи үзлийн үүднээс авч үзвэл Тэр нь теист шинжтэйг германы энэ сэтгэгч үгүйсгэсэн мөрүүд бичээгүй байна. Харин Библийн нөгөөх үндсэн хэсэг болох Шинэ Гэрээ(New Testament)-г бүрдүүлж буй номнууд Дивангарын Гэрээн дэх Бурхан тэнгэрийг хэрэг дээрээ үгүйсгэдэг гэж Ф.Ницше үзсэн байна. Хоёрдугаарт, Ф.Ницше бол атеизмын өвөрмөц нэг хэв маягийг бүтээгч мөн гэж үздэг үзэл зүйтэй юм.

Ийм хоёр дүгнэлтийг Ф.Ницшегийн бараг сүүлчийн нь бүтээл болох "Христийн эсрэг үзэлтэн. Христос шашныг жигшсэн нь" номыг онцлон авч үзэх замаар хийж буй болно.

Ф.Ницше 1888 онд "Христийн эсрэг үзэлтэн. Христос шашныг жигшсэн нь" гэдэг 5х.х. шахам хэмжээтэй ном бичиж дуусгасан аж. Харин тэрээр нийтлэлийн тодорхой зорилгынхоо үүднээс энэ номоо хэвлүүлэхээ азнаж байжээ. Тийм учраас нас барснаас нь хойш 1895 онд энэ ном анх хэвлэгдсэн байна.

"Христийн эсрэг үзэлтэн" зохиолын агуулгыг би авч үзэхийнхээ өмнө энэ зохиолтой танилцах зорилго тавьсан, гэхдээ христос шашны талаар мэдээлэл

багатай хүмүүст хандаж христос шашны уг сурвалж, агуулгын талаар цөөн үг хэлье (ингэх шаардлага Ф.Ницшегийн эл бүтээл дэх судалгааны онцлогоор нөхцөлдөж буй болно).

Монголд олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөх болсон 1990-ээд оноос хойш манайхан жүүд шашны болон христос шашны судруудын эмхэтгэл болох Дивангарын Гэрээ, Шинэ Гэрээ хоёрыг эх хэл дээрээ чөлөөтэй уншин судлах бололцоотой болсон билээ. Гэхдээ уншигчдын маань нэг хэсэг нь Библийн энэ хоёр хэсгийн тус тусын үүссэн шалтгаанд болон агуулгын зориулалтанд ямар чухал ялгаа байдгийг анзаардаггүй тал ажиглагддаг юм.

Дивангарын Гэрээ бол хр.т.ө. XII зуунаас хр.т II зуун болон VII-IX зуун хүртэлх 2000 орчим жилийн хугацааны шидэт домог, эртний түүхэн товчоо, түүхэн өгүүлэл, сургаал, айлдвар, ёслолын болон мөргөлийн дуулал, хайр сэтгэлийн ба эр эмийн ёсны тухай өгүүлэл, танин мэдэхүйн үйлд өгсөн үнэлгээ зэргийн цогцоос бүрдсэн бүтээлүүдээс шигшин цэгцэлсэн хураангуй байдаг. Дивангарын Гэрээ нь хр.т.ө. I мянган жилийн хугацаанд палестиний еврей нарын шашин болж хувирчээ. Түүнийг "жүүдийн шашин (judaism)" гэж нэрлэдэг. Улмаар Ази, Европын бусад ард түмний дунд энэ шашин дэлгэрэхдээ библийн (дивангарын) шатнаас XX зууны модернист хүртэлх олон шат, хэлбэр дамжин оршиж, тэдгээр тус бүр нь Дивангарын Гэрээний зөвхөн тодорхой тодорхой номлол, ёс жаягийг нь илүүтэй онцолдог ажээ.

Дивангарын Гэрээ түүхэн бүрэлдлийн хувьд ийнхүү жүүдийн шашныг төрүүлсэн аж. Гэхдээ энэ шашин Шинэ Гэрээг баримталдаггүй.

Харин христос шашин бол Дивангарын Гэрээг хүлээж аваад түүндээ үндэслэн Шинэ Гэрээг бүтээсэн шашин мөн. Үүнд, энэ шашин I зуунд үүсээд IV зуунд Ромын империйн хувьд төрийн шашин нь болж, улмаар түүнээс хойшхи 1600 орчим жилийн хугацаанд олон салбарлаж, олон шат дамжин орших болж, дэлхийн бөмбөрцгийн бүх бүс нутагт ямар нэг хэмжээгээр дэлгэрч иржээ.

Жүүдийн шашинд үзэхдээ Дивангарын Гэрээ бол энэ дэлхийн, хүний бүтээл биш, харин Бурхан тэнгэр (God) "дээрээс өөрөө нээгдсэн" нь мөн гэдэг. Тухайлан хэлэхэд Дивангарын Гэрээнд түүний хамгийн гол бүрэлдэхүүн Таван номыг Бурхан тэнгэр өөрөө Моисейд Синайн ууланд гардуулсан гэж өгүүлдэг. Харин ингэж өгүүлдгийг шинжлэх ухааны төлөөлөгчид үл зөвшөөрдөг юм. Гэтэл христос шашин Дивангарын Гэрээг төдийгүй Шинэ Гэрээг ч гэсэн Бурхан тэнгэрийн дээд нээгдэл гэж үздэг бөгөөд энэ номлолыг шинжлэх ухааны төлөөлөгчид бас үл зөвшөөрдөг юм.

Христос шашинд Дивангарын Гэрээг яаж хүлээж авдаг вэ? гэвэл энэхүү судрын эмхэтгэлд зөгнөсөн мэдээнүүд, тухайлбал дэлхийд аврагч ирэх тухай мэдээ дэлхийд биеллээ олж байна хэмээн Шинэ Гэрээнд шаргуу өгүүлдэг билээ.

Шинэ Гэрээнд мэдээлснээр Есүс бол Бурхан тэнгэрийн шийдэл ба шидээр Марь гэгч онгон хэвээр буй бүсгүйгээс төрж, тэгээд ядарч зовсон хүмүүсийг аврагч тийм бурхан тэнгэрэн хүн мөн ("Есүс" гэдэг нь "аврагч", "Христос" гэдэг нь "халхлагч", "авран ангижруулагч" гэсэн утга бүхий үг аж).

Дивангарын Гэрээнд мэдээлдгээр гэм хийсэн хүн бүр Бурхан тэнгэрээс салах ёстой бөгөөд тэр салалт нь үхэл юм. Гэтэл нэг ч хүн гэмээс мултраагүй тул Бурхан тэнгэрийн шийтгэл тэдэнд бүгдэд очих ёстой байв. Гэвч Бурхан тэнгэр хязгааргүй хайрынхаа улмаас хүн төрөлхтөнийг үхлээс аврахын тулд хүү Есүсийгээ тийнхүү дэлхийд илгээж, Тэр нь Палестин даяар шинэ шашин номолж, олон гайхамшигт үйл бүтээгээд төгсгөлд нь эцэг Бурхан тэнгэрийнхээ зарлигаар хүн төрөлхтнийг аврахын тулд амиа золисолон, буруу номтнуудад (эсэргүүцэл гаргалгүй) цовдлуулсан байна. Гэвч Есүс гурав хоногийн дараа дахин амилаад тэнгэрт гарчээ.

Би христос шашнаас дурдах гэсэн зүйлсээ үүгээр хязгаарлаад үндсэн сэдэв рүүгээ шилжин өгүүлэхэд Ф.Ницше "Христийн эсрэг үзэлтэн" зохиолдоо Дивангарын Гэрээг цөөнгүй хөндсөн ч гэсэн гол анхаарлаа Шинэ Гэрээнд хандуулсан байна. Тэрээр ингэхдээ христос шашны үндсэн агуулга, нийгмийн зориулалт, ёс суртахууныг болон энэ шашны теологийг философи, шашин судлал, бас соёлын онол зэргийн уялдаан дээр хурц шүүмжилжээ. Уг зохиолын нэрэн дэх "христийн эсрэг үзэлтэн" гэдэг нь Ф.Ницше өөрөө юм. Нэг баримт дурдахад тэрээр 1883 оны дөрөв дүгээр сарын 3-4-нд Мальвид фон Мейзенбургд бичсэн захидалдаа: миний шинэ нэрнүүдийн нэгийг Танд сонсговол таалах уу? Сүм хийдийн хэлээр тэр нэр: би бол Христийн эсрэг үзэлтэн мөн гэж байгаа хэмээн бичсэн байдаг тухай К.А.Свасьян "Христийн эсрэг үзэлтэн" зохиолд хийсэн Тайлбартаа дурдсан буй.

**Ф.Ницше христос шашныг шүүмжлэхдээ
генеалоги аргыг ашигласан нь.**

Ф.Ницше энэ зохиолынхоо 39§-ийн эхэнд: "христос шашны үнэн түүхийг өгүүлье. Бүр "христос шашин" гэдэг үг бол дутуу бодлынх юм. Өөрөөр хэлбэл угтаа ганц христосч хүн байсан бөгөөд тэр хүн цовдлуулж үхсэн. "Евангали (Есүс дэлхийд хэрхэн амьдарсан тухай өгүүлсэн христос шашны зохиолуудад өгсөн "буянт мэдээ" гэсэн утга бүхий ерөнхий нэр—Ц.Г.) цовдлуулж үхсэн. Энэ агшнаас хойш "Евангали" гэж

нэрлэгдэх болсон зүйл аваас түүний оршихуйд бүр эсрэг шинжтэй, "муу мэдээ"... болжээ"².

Ф.Ницшегийн эл өгүүлснийг мөнхийн буцалтын тухай түүний философи баримтлалтай нь уялдуулан ойлговол Есүс манай дэлхийд төрж, шашин дэлгэрүүлж, олон гайхамшгийг бүтээгээд өөрийгөө хүн төрөлхтний төлөө золиослон хүлцэнгүй цовдлуулснаар Түүний буянт үйл ба Түүний тухай буянт мэдээ дуусгавар болсон юм. Есүсийг цовдлуулснаас хойшхи Түүний талаархи мэдээнүүд худлаа байдаг.

Аль ч евангалид гардгаар Есүс бол сул доройчуудыг, ядуусыг хамгаалж, аврагч мөн. Иймээс тэдгээр ном нь Хүүгээ ширүүлж, золиосолдог Бурхан тэнгэрийн үйлдэлд эсрэг муу мэдээ түгээгчид мөн бөгөөд христос шашин бол resentment өсөрхөх инстинктийн бүтээгдэхүүн юм гэж Ф.Ницше бичжээ.

Ф.Ницше шашин үүссэн сэтгэл зүйн үндсийг тийнхүү инстинктив шинжтэй гэж үзсэн.

**Ф.Ницше шашны ба теологийн зарим ойлголтонд
газар дэлхийн утга бүхий философи
ойлголтуудыг сэргүүлэн тавьсан нь.**

Ф.Ницше христос шашны олон ойлголтыг үгүйсгэхдээ заримынх (тухайлбал "сайн", "муу" гэх мэт-ийн) нь агуулгыг шинэ утгатай болгох, заримыг нь ерөөсөө үгүйсгэх зэрэг янз бүрийн арга хэрэглэжээ. Энэ шашны ойлголтуудыг үгүйсгэхэд чиглэсэн тийм сэргүүлэх үйл ажиллагаа Ф.Ницшегийн өмнөх зохиолуудад ч байсан болохыг өмнө холбогдох газруудад нь дурдсан билээ. Тэгвэл уг ажиллагаа "Христийн эсрэг үзэлтэн" зохиолын дайвар биш, харин зориудын нэг чухал зорилт байсан гэж болмоор юм. Тийм зорилт аваас нэн түрүүнд дараахь чиглэлүүдээр хэрэгжиж иржээ. Үүнд:

-Юу сайн бэ? гэвэл эзэрхэх мэдрэмжийг, эзэрхэх хүсэл эрмэлзлийг өөрий нь хүмүүст дээшлүүлдэг бүхэн сайн. Юу муу вэ гэвэл сул доройгоос үүсдэг бүхэн муу. Аз жаргал гэж юу вэ? гэвэл улам улам эзэрхэж байгаагаа мэдрэхүй, дийлдэшгүй эсрэг үйлдлийн мэдрэхүй мөн гэсэн атеист томъёоллууд Ф.Ницше дэвшүүлсэн юм³.

-Христос шашин аваас үлэмж хүний үндсэн бүх инстинктээс хол байдаг⁴ гэж Ф.Ницше үнэлдэг. Тэгээд тэрээр тайвшралыг биш, харин эзэрхэх хүсэл эрмэлзлийг; энх амгаланг биш, харин дайн тулааныг; буянт үйлийг биш, харин авъяас билгийн давууг дээдлэн тунхаглажээ.

Ницше ийм газар дэлхийн амьдралын утгат, шинэ үнэлэмжийнхээ үүднээс христос шашны ёс суртахууны олон ойлголтын агуулгыг өөрчилсөн байна. Зарим жишээ гаргая.

1. *Христос шашин бол сул доройчуудыг, өвчин эмгэгт нэрвэгдэгчдийг, гэм хийгчдийг аврахын төлөөх нигүүлслийн шашин мөн гэж Ф.Ницше дүгнэдэг юм*⁵. Харин тэрээр өөрөө хүний амьдралд зовлон, нигүүлсэл хоёр ямар гүйцэтгэл бүхий болохыг христос шашинд ярьдгаас ялгаатй тайлбарласан буй. Түүний үзлээр нигүүлсэл бол эзэрхэх хүсэл эрмэлзлийг сулруулж, багасгадаг бөгөөд харин зовлон бол хүн өөрийгөө эзэмдэх, өөрийгөө мэдрэх, өвчин шаналгаагаа ялах, эзэрхэх хүсэл эрмэлзлээ хөгжүүлэх зэрэгт түлхэц өгдөг. Тийнхүү дионисч сэтгэл, эзэрхэх хүсэл эрмэлзэл бол нигүүлслээс зугтаж, өвчинг оронд нь тунхагладаг гэж Ф.Ницше үзсэн билээ. Тэрээр: сул доройчууд үхэх ёстой гэдэг бол бид хүнийг хайрлахын анхдагч үндэслэл мөн. Азгүйчүүд, сул доройчуудыг нигүүлсэх христосын ёс бол маш хортой гэж шууд өгүүлсэн юм⁶.

“Христийн эсрэг үзэлтэн” зохиолын 9§ нь нигүүлсэл угтаа Есүсийн хайранд ба үйлдэлд биш, харин амьдралд, үлэмж хүний инстинкт ба хүсэл эрмэлзэлд хэрэгждэг гэсэн санааг хамгаалжээ. Христос шашны нигүүлсэл яагаад жинхэнэ нигүүлсэл биш вэ? гэвэл тэр нь амьдралын үнэлэмжийг тэтгэн дээшлүүлдэг инстинктүүдийг устгаж, амьдрах мэдрэмжийн эрчмийг өсгөдөг цухалдлыг унтрааж, бүхэлдээ амьдралыг үгүйсгэж байдаг хэмээн тэнд бичсэн байдаг.

2. *Христос шашны шүтлэг, үйлдэл бүхий хүн бол “гэрийн амьтан”, “сүргийн амьтан” мөн хэмээн Ф.Ницше томъёолсон юм*⁷. Тэгээд тэрээр хүн бүхэлдээ бол “бүрэлдэж хараахан дуусаагүй амьтан мөн” гэж бичсэн байдаг. Гэвч энэ бол хүний зөвхөн дутуу дулимаг нь биш, бас бололцоо нь мөн гэж Ф.Ницше үзсэн юм. Тодруулж хэлбэл хүн бол ямар нэг юм биш, харин юу ч болж мэдэх зүйл мөн.

Тийнхүү хүний мөн чанар бол бүрэлдэж дуусаагүй нь биш, харин тэр (хүн) нь өөрийн хязгаараас гарч чадахуй нь, үүнд үлэмж хүн болж бүрэлдэх бололцоо нь мөн.

3. *“Бие” гэдэг христос шашны ойлголтыг Ф.Ницше бас өөр агуулгаар тайлбарласан байна.* Христос шашны үүднээс бие бол Бурхан тэнгэрийн бүтээл, сэтгэлтэй харьцуулбал дорд зүйл мөн. Тиймээс энэ шашин даяанчлал (өөрөөр хэлбэл өөрийгөө гэсэн ressentiment), цовдлон алах (өөрөөр хэлбэл бусдыг гэсэн ressentiment) зэрэг үйлдлийг хүртэл бий болгожээ.

Харин Ф.Ницшегийн хувьд бие бол нэн чухал эерэг зүйл мөн. Тэрээр ганц "Христийн эсрэг үзэлтэн" зохиолдоо биш, бас өөр олон зохиолдоо философийг нэгэн төрөл бүжиг (танец) гэж үзэхдээ түүнийг сэтгэлийн биш, харин биеийн бүжиг гэж үзэж байв. Ингэхдээ биеийг мах цусан бодос гэж явцуугаар ойлгохоос зайлсхийж, улмаар өөрийн зохиол, афоризмын эмхэтгэл, дионисон сэтгэлийн бахархал зэргээ объективчлогдсон байдлыг "бие" гэж илэрхийлж байв.

Тийнхүү Ф.Ницшегийн хувьд бие бол аливаа төрлийн зохистой бүрэлдэл, өөрөөр хэлбэл тодорхой махбод биш, харин түүний тухай мэдрэмж, сэтгэгдэл оюуны бүтээл, тэмдэглээ зэрэг юм.

Ф.Ницше тийм объективчилсон биеүд дотроос хүсүүштэй биеүдийг нь онцлоод тэдгээрийг бүтээх маш чухал нэг нөхцөл бол мах цусан бие, тухайлбал өвчин мөн гэж үзжээ.

4. *Ф.Ницше олон бүтээлдээ "бие" гэдэг ойлголтыг "гэрэл", "сүүдэр" гэдэг ойлголтуудтай холбон тайлбарласан юм.* "Христийн эсрэг үзэлтэн" зохиолд бичсэнээр бие, гэрэл хоёр нэгдмэл байдаг. Ф.Ницше үдийг магтан дууддаг. Энэ нь үдийн нарны үед биеийг хуурамч бодит байдлаар бүрхдэг сүүдэр арилаад бие, гэрэл хоёрын нэгдэл тодорхой болдог гэсэн утга илэрхийлдэг.

Христос шашин бол бүрэнхий мөн тул тэр нь бие ч биш, гэрэл ч биш, харин хуурамч бодит байдал мөн гэж Ф.Ницше дүрслэн бичсэн юм. Энэ нь гэрэл бол бие өөрийнхөө хязгаарыг өөрөө давах нөхцөл мөн гэж тэрээр үздэгтэй нь уялддаг.

5. *Танин мэдэхүйн талаархи жүүд шашны болон христос шашны үнэлэмжийг Ф.Ницше шүүмжилсэн юм.* Библи бол эхнээсээ л хүн танин мэдэх чадвартай байхаас эмзэглэдэг мөрүүд бүхийг Ф.Ницше тэмдэглэсэн байдаг. Ингэхдээ тэрээр дараахь хэдэн санааг онцлон илэрхийлжээ. Үүнд⁸:

-Библи дэх "буруу үйлдэл", "гэм", "шийтгэл" зэрэг ойлголт бол танин мэдэхүй, шинжлэх ухааны эсрэг бүтсэн;

-Христос шашин гагцхүү ядруу оюун ухааны гачаалыг хангадаг;

-Энэ шашны үүднээс эргэлзээ бол гэм мөн;

-Угтаа аугаа ухаантнууд бол скептикчид мөн. Тухайлбал Заратустра бол скептикч;

• -Итгэл үнэмшил бол шорон мөн. Түүний нөхцөлд алсыг харах, өөрийгөө олж мэдэх бололцоо байдаггүй;

-Сүсэгтэн хүн өөртөө хамааралгүй байж, гагцхүү хэрэгсэл, ашиглагдагч болж байдаг;

-Бишрэл бол үнэнийг мэдэж авахыг үл хүсдэг байдал мөн;

-Сүм хийдийн томчуулын хувьд нэг л айхтар аюултай дайсан байдаг нь шинжлэх ухаан мөн. Хүн биеэсээ гаднах юмыг судлаачийн нүдээр харах нь гэм мөн. Хүн зовлонд байх ёстой. Энэ нь түүнд сүм хийд хэрэг болж байг гэсэн үг. Хүн сэтгэл ба цагийн хувьд завгүй, өөрөөр хэлбэл зовж байвал зохино. Тийм нөхцөлд хүн танин мэдэхүй, шинжлэх ухаанаас хол, харин сүм хийдэд ойр байдаг. Тийнхүү сүм хийд бол шалтгаачлын мэдрэмж хүнд үүсэхийг хааж, шалтгаан ба үйлдлийн тухай ойлголтуудыг хорлож, ингэснээрээ танин мэдэхүйн нэн чухал нөхцлүүдийг үгүйсгэж байдаг;

-Теологич хүн үнэн гэж боддог бүхэн худлаа байх ёстой бөгөөд энэ бол үнэний шалгуур бараг мөн.

6.Атеизм. "Ямар ч бурхан тэнгэр, ямар ч "гэмтэн", ямар ч "аврагч" байхгүй, өөрөөр хэлбэл "эрх чөлөөт хүсэл эрмэлзэл", "ертөнцийн тухай зан суртахууны дэг журам" гэдэг бол худлаа гэдгийг сүм хийдийн дээдэс сайн мэддэг"⁹ хэмээн Ф.Ницше бичсэн байдаг.

Гэхдээ Ф.Ницшегийн энэ үг Дивангарын Гэрээнд биш, харин Шинэ Гэрээнд холбогдож буйг анзаардаг байх ёстой. Яагаад гэвэл Дивангарын Гэрээнд Бүтээгч Бурхан тэнгэрийн тухай өгүүлсэн бол Шинэ гэрээнд Бурхан тэнгэр бол Эцэг, Хүү, Ариун сүнс гэдэг гурван төрхтэйн тухай өгүүлж, тэгээд бас тэнд Бурхан тэнгэр хэрэг дээрээ бүтээгч биш, харин бие хүн, түүгээр ч зогсохгүй сүм хийдийн номлол болж хувирсан гэсэн санааг Ф.Ницше илэрхийлсэн юм. Түүний тайлбараар Бурхан тэнгэрийн гурван төрх бол сэтгэлийн бэлгэдэл¹⁰ бөгөөд Бурхан тэнгэр лүү хүргэх зам бол наминчлал, мөргөл биш, харин евангалич практик мөн. Ер нь Шинэ Гэрээний хувьд евангалич практик бол "Бурхан тэнгэр мөн"¹¹.

Ф.Ницшегийн энэ өгүүлснээс дүгнэлт хийвэл жүүд шашин, түүний агуулгыг бүрдүүлэгч Дивангарын Гэрээ нь теизмийг номолдог ахул Шинэ Гэрээ нь хэрэг дээрээ Бүтээгч бурхан тэнгэрийг биш, харин атеизмыг сурталчилжээ.

Энэ дүгнэлтээ нотлох нэг үндэслэгээ нэмж дурдаад Ф.Ницше бичихдээ: Христос буюу "Хүнэн хүү", "Бурхан тэнгэрлэг хүү" гэдэг ойлголт бол "түүхэнд хамаардаг тодорхой бие хүн, жич нэгж, ганц юм биш, харин "мөнх" бодит байдал, цаг хугацааны тухай ойлголтоос чөлөөлөгдсөн психологи бэлгэдэл мөн"¹² гэсэн байдаг.

Тэгвэл ийм "мөнх бодит байдал" болох Христос нь Бүтээгч мөн үү, биш үү? Ийм асуултын хариулт болох зүйлийг Ф.Ницше бичихдээ: Аврагчийн амьдрал нь ч, үхэл нь ч евенгали практик мөн. Аврагч бол ганц бөгөөд Тэр бол "аврах" психологи бодит чанар мөн. Өөрөөр хэлбэл шинэ бишрэл биш, харин шинэ авир үйлдэл мөн гэсэн юм¹³. Тийнхүү Шинэ Гэрээн дэх Христос бол Бүтээгч биш, харин шинэ амьдрал, шинэ авир үйлдлийн загвар, үлгэр жишээ мөн гэсэн үзлийг Ф.Ницше сурталчилжээ. "Христос шашин дахь (Бурхан тэнгэр бол эмгэгтнүүдийн Бурхан тэнгэр мөн, Бурхан тэнгэр бол хүнийг хамагч, Бурхан тэнгэр бол санаа мөн гэдэг) бурхан тэнгэрийн тухай ойлголт бол бурхан тэнгэрийн тухай энэ дэлхий дээрх хамгийн завхарсан ойлголтуудын нэг мөн"¹⁴ гэж тэрээр тэмдэглэсэн байдаг.

7.Теологи, идеализм хоёрын холбооны тухай. Ф.Ницше теологи, идеализм хоёрт зохисгүй төсөө байна гэж үзсэн байдаг. Үүнд, теологичид өөрсдийгөө идеалист хэмээн ихэмсэглэж, идеализм нь "оюун ухаан", "мэдрэмж", "нэр төр", "сайн сайхан", "шинжлэх ухаан" гэх мэт ойлголтыг басамжилж, шашныхны адилаар нүсэр нүсэр ойлголт хэрэглэдэг хэмээн тэрээр шүүмжилжээ¹⁵.

8.Ухамсар, сэтгэхүй, хэлний асуудлыг Ф.Ницше христосч биш байрнаас тайлбарласан аж. Теологийн төлөөлөгчид хүний санаа, ухамсрыг хүн дээд гаралтай, бурхан тэнгэрлэг шинжтэйгийн нотолгоо мөн хэмээн үзэж ирснийг Ф.Ницше үл зөвшөөрсөн юм. Тэгээд тэрээр: тийм теологи үзэлд сөргүүдсэн тайлбар хийхдээ "харин ч чухамхүү ухамсар, "санаа" бол амьд биесийн харьцангуй төгс бишийн шинж тэмдэг, мэдрэхүйн хүчээ ашиг нэмэр олохгүй зөнд нь үрж буй чармайлт, оролдлого, тэмтрээн, будилалт мөн гэж бид үздэг. Ямар нэг юмыг ухамсартай хийсэн бол түүнийг төгс болсон гэдгийг бид үгүйсгэдэг... "Цэвэр санаа" бол жинхэнэ тэнэглэл мөн"¹⁶ гэж бичсэн байна. Улмаар тэрээр: сэтгэнэ гэдэг бол ойлголтуудад анхны нь утгыг, ойлголтын хэлэнд арчигдсан зүйрлэл (метафори) шинжийг буцааж оруулна гэсэн үг мөн. Тийнхүү сэтгэхүй бол биеийн бүжиглээгээр төрдөг. Бүрэлдэл бол бас хэлийг даван туулахуй мөн гэж тэмдэглэжээ.

Ф.Ницше тийнхүү бие бол урлан буюу бүрэлдэл мөн гэж үздэг үзлийнхээ үүднээс биеийг чөдөрлөгч нь сэтгэхүй, сүргийн ёс суртахуун мөн гэж тайлбарладаг юм.

Шашин судлалын зарим асуудал.

Ф.Ницше "Христийн эсрэг үзэлтэн" зохиол дахь философи баримтлалууддаа нэг талаар эмпирик уг сурвалж нь, нөгөө талаар нотлох үндэслэгээ нь болж өгдөг

чухал чухал дүгнэлтийг уг бүтээлдээ шашны философи, шашин судлалын уялдааны үүднээс хийжээ. Тэдгээрээс зарим голыг нь дурдъя.

1. *Есүсийг цовдолсонд өгсөн үнэлгээ.* "Ариутгагч золиос", тэхдээ бүр хамгийн гутмаар, хамгийн бүдүүлэг хэлбэртэй, буруу үйлдэлтнүүдийн гэмийн төлөөсөнд буруугүйд оноосон золиос"¹⁷.

2. *Христос шашны түүхэн үйлүүд.* Христос шашинд болбоос захирагдагч, дарлагдагч нарын инстинкт тод илэрдэг. Чухамхүү доодос энэ шашнаас аврал хайдаг. Энэ шашин бол оюунлаг байдал, бардам зан, эрэлхэг зориг, эрх чөлөө зэргийг үзэн ядагч мөн. Христос шашин хорлох, гүжирдэх, амьдралыг үгүйсгэх, биеийг басамжлах, гэмийн тухай ойлголтыг ашиглаж байгаад хүнийг өөрийг нь өөрөөр нь бузарлуулан хөнөөх зэрэг олон муу зорилго, олон муу хэрэгсэлтэй¹⁸.

3. *Дэлхийн том шашнуудыг харьцуулсан дүгнэлтүүд.* "Христийн эсрэг үзэлтэн" зохиолын 20§-д христос шашин, буддизм хоёрын нийтлэг ба ялгааны талаархи үзлээ Ф.Ницше илэрхийлсэн юм. Тэрээр христос шашин, буддизм хоёр "...хоёулаа decadence шашнууд мөний хувьд нигилист шашнуудад багтаж байдаг"¹⁹ гэсний сацуу хоёулангийнх нь ноцтой ялгааны тухай дурдсан юм. Үүнд, буддизм бол "христос шашнаас зуу дахин бодитой. Яагаад гэвэл энэ шашин асуудлыг объектив байрнаас, олон таван санаархалгүй дэвшүүлдэг уламжлалтай. Буддизм хэдэн зуун жил үргэлжилж ирсэн философи хөдөлгөөний дараа бий болж, анх бий болохдоо л "Бурхан тэнгэр" гэдэг ойлголтыг шууд үгүй хийсэн. Буддизм бол түүхэнд тохиож буй ганц жинхэнэ эерэг шашин мөн. Энэ шашин танин мэдэхүйн онолдоо (чанд феноменализмдаа) хүртэл "гэмийн эсрэг тэмцэл" гэж ярьдаггүй бөгөөд харин "зовлонгийн эсрэг тэмцэл" хэмээн бодит байдлыг бүрэн ойлгон өгүүлдэг"²⁰ гэж тэрээр бичсэн байна.

Лалын шашин ч гэсэн христос шашныг басамжилдаг нь зөв бөгөөд учир нь, лалын шашин бол эрдүү шашин мөн гэсэн санааг Ф.Ницше бас илэрхийлсэн юм²¹.

***Нийгмийн үзлийн салбар дахь
зарим үндэслэгээ.***

Ф.Ницше "Христийн эсрэг үзэлтэн" зохиолдоо философи үзлээ гүнзгийрүүлсэн нь түүний нийгмийн үзэлтэй нь уялддаг.

Уналт. Эзэрхэх хүсэл эрмэлзэл дутаж буй газарт уналт болж, нигилист үнэлэмжүүд ноёрхдог гэж Ф.Ницше үзсэн юм²². Тэгээд тэрээр "уналт" гэдэг ойлголтыг "хүний завхрал" гэдэг ойлголттой ижил утгатай гэсэн байна.

Ф.Ницше ардчилал, либерализмын онол, практикийг хүний завхрал, уналт (decadence)-ын хамгийн тод илрэлүүд гэж үзсэн юм. Тийм учраас тэрээр өөрийн үеэ дэвшлийн (прогрессийн) үе гэж үзэхийг зөвшөөрөөгүй билээ. “Хүн төрөлхтөн бол эдүгээ хүртэл итгэсээр байгаа шигээ шилдэг рүү буюу хамгийн хүчтэй рүү, эсвэл хамгийн дээд рүү хөгждөг биш ээ. “Дэвшил” гэдэг бол гагцхүү орчин үеийн санаа, өөрөөр хэлбэл хуурамч санаа мөн. Өнөөгийн европ хүн үнэлэмжээрээ сэргэн мандалтын эриний европ хүнээс хамаагүй доогуур”²³ гэж тэрээр тэмдэглэжээ.

Бурхан тэнгэрийг биш, харин хүнийг дээдлэхэд шилжсэн, христос шашны ёс суртахууны дөнгөнөөс хүний хүсэл эрмэлзэл болон оюун ухааныг чөлөөлж эхэлсэн, ёс суртахууны зарчмуудыг зорилгоо биелүүлэхэд захируулдаг болсон зэрэг Сэргэн мандалтын төлөөлөгчдийн шинэ үнэлэмжийг ихэд ойшоосон ийм дүгнэлт нь Ф.Ницше ressentiment үзэл, үйлдлийг эрс шүүмжилдгийг санагдуулж байна.

Дэвшил бол тийнхүү христос шашны ёс суртахуун, ардчилал, либерализм зэргийн алинаар ч хангагдахгүй гэж Ф.Ницше үзсэн юм²⁴.

Харин үлэмж хүний хэв маяг бол дэвшлийн үндсэн үзүүлэлт болж чадна гэж тэрээр үзсэн. Үүнд: дэлхийн бөмбөрцгийн янз бүрийн нутагт, өөр өөр соёлын хүрээнд нийт хүн төрөлхтнөөс дээд хэв маяг болох үлэмж хүн төрөлхтөн онцгой тохиолдол байдлар үүсэж чадна. Тийм азтай тохиолдол урьд ч гарч байсан бөгөөд ирээдүйд ч бололцоотой. Аятай нөхцөл бүрдвэл бүхэл бүтэн үеийнхэн, овог аймаг, ард түмэн тийм үлэмж хүн төрөлхтөн болж чадна хэмээн Ф.Ницше бичсэн билээ²⁵.

Ийнхүү Ф.Ницшегийн үзлээр дэвшил бол нийт хүн төрөлхтөнд, тухайн нийгэмд бүхэлд нь холбогдох албагүй бөгөөд тэр нь үлэмж хүний хэв маяг бүрэлдэж буй эсэхээр хангагдах ёстой аж.

Ф.Ницше анархизмыг тэвчихгүй байгаагаа илэрхийлэхдээ түүнийг нийгмийн зориулалтын хувьд христос шашинтай адил гэж үзсэн юм. Үүнд: христос шүтлэгтэн, анархист хоёрын аль алины зорилго, инстинкт нь өөдрөг, ихэмсэг, ирээдүйтэй бүхнийг үзэн ядаж, эвдрэл бий болгодог хэмээн тэрээр дүгнэсэн байдаг²⁶.

х х х

Ийнхүү Ф.Ницше атеизмын нэн өвөрмөц хэв маяг бий болгосон нь түүний “Христын эсрэг үзэлтэн. Христос шашныг жигшсэн нь” гэдэг шинэлэг агуулгынхаа хувьд хамгийн сүүлчийн бүтээлд нь илүү тод илэрчээ.

Резюме

Данная статья называется: "Обоснование Ф.Ницше атеистичности христианства". По мнению автора статьи Ф.Ницше не отрицает теистичность содержания Ветхого завета, а что касается Нового завета, то немецкий мыслитель обосновывает атеистичность его содержания и вообще сам Ф.Ницше создал свой специфический тип атеизма.

НОМ ЗҮЙ

1. Энэ чиглэлээр манайд явуулсан сүүлийн үеийн нэг судалгааны нэр дурдахад: Б.Ичинхорлоо. Ф.Ницшегийн философид атеизм хэрхэн холбогдох нь. – Дэлхийн философийн өдөрт зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2005, 99-110 дахь тал
2. Ф.Ницше. Антихрист. Проклятие христианству.-Ф.Ницше. Сочинения в двух томах. Т..2,с.663
3. См. об этом: там же, с.633
4. См. об этом: там же,с.634
5. См. об этом напр.: там же, 7§
6. См. об этом: там же, с.633
7. См. об этом: там же, с.634
8. См. об этом: там же, 49§-56§
9. Там же, с.662
10. См. об этом: там же, с.559, 560
11. См. об этом: там же, с.659
12. Там же, с.659-660
13. См. об этом: там же, с.659
14. Там же, с.644
15. См. Об этом: там же, с.637
16. Там же, с.641
17. Там же, с.665
18. См. об этом напр.: там же, с.646, 683
19. Там же, с.645
20. Там же
21. См. об этом напр.: там же, с.689
22. См. об этом: там же, с.635
23. Там же, с.634
24. См. об этом: там же, с.634
25. См. об этом: там же
26. См. об этом напр.: там же, с.686,687